

## Боловсролын нэр томьёоны орчуулга

Таванжингийн Уянга 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Англи хэлний тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:  
2023-11-10

Засварласан - Revised:  
2023-12-15

Хэвлэгдсэн - Published:  
2023-12-26

uyanga@msue.edu.mn

ORCID:[0009-0002-7211-3875](https://orcid.org/0009-0002-7211-3875)



© 2023, Author(s)

**Хураангуй:** Сүүлийн жилүүдэд дээд боловсролын салбарт сургалтын шинэ арга зүй, технологи нэвтэрч, судалгааны ажлын цар хүрээ улам тэлж байна. Үүний нөлөөгөөр тус салбарт гадаад хэлнээс орж ирсэн шинэ нэр томьёог сургалт, судалгаандаа хэрэглэж байна. Их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачдад шинэ нэр томьёог судалж, зөв оновчтой хэрэглэж сурах хэрэгцээ шаардлага тулгарч байна. Энэ өгүүллийн эхний хэсэгт нэр томьёоны онцлог шинж, бүтэц, нэр томьёонд тавигдах шаардлага зэргийг авч үзэв. Судалгааны хэсэгт дээд боловсролын салбарт гадаад хэлнээс орж ирсэн зарим нэр томьёоны гарал үүсэл, утга, хэрэглээг судалсан болно.

**Түлхүүр үг:** Гадаад үгс, нийлэмж үг, үгийн гарал, утга, хэрэглээ

### Удиртгал

Сүүлийн жилүүдэд нийгэм, улс төр, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, техник технологи зэрэг бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт эрчимтэй явагдаж, шинэ нээлтүүд гарч, улс орон бүрд тэдгээрийг нэрлэх оновчтой үг хэллэг, нэр томьёог хэрэглэх нийгмийн хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Дээд боловсролын салбарт олон улсын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж буй энэ үед монголын их, дээд сургуулиуд хөтөлбөрөө олон улсад магадлан итгэмжлүүлэх, сургалтын журам, баримт бичиг, магадлангийн тайланг англи хэл дээр орчуулах, суурь судалгаа хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаадад эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх зэрэг сургалт судалгааны ажилд тус салбарын нэр томьёог англи хэл рүү зөв орчуулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Мөн дээд боловсролын салбарт гадаад хэлнээс орж ирсэн шинэ ухагдахуун, нэр томьёоны талаар нэгдсэн ойлголттой болж, тэдгээрийг монгол хэлэнд зөв оновчтой орчуулан, хэрэглэж хэвших нь чухал байна.

### 1. Нэр томьёоны талаарх үндсэн ойлголт

Бидний өдөр тутмын амьдралд шинэ, шинэлэг техник технологи чухал үүрэг гүйцэтгэж, аль ч салбарт шинэ нэр томьёо олноор бий болж, харь хэлнээс монгол хэлний үгийн санд нэмэгдсээр байна. Энэхүү хөгжил дэвшил нь бидэнд дэлхийн бусад улс орнуудтай хөл нийлүүлэн алхаж, хамт хөгжих боломжийг олгох байгаа хэдий ч үүний үр дүнд нэр томьёо нь ямар ч оноосон монгол нэргүй, шууд галигчлан хэрэглээнд орж эх хэлний дархлааг сулруулж байна.

Нэр томьёо гэдэг нь (“terminus”- латин үг, утга нь хил хязгаар ) олон сав ухаан буюу ертөнцийг танин мэдэхүйн хүрээнд хүмүүний үйлийн ухагдахууныг тэмдэглэсэн үг, түүний нийлэмжийг хэлнэ. Аливаа шинэ ухагдахууны нэр нь тухайн салбарын нэр томьёоны дэд тогтолцоог дамжин нийтийн хэлний үгийн сангийн хөмрөгт ордог.

Нэр томьёоны өвөрмөц онцлог шинж:

- тогтолцоот чанар
- ухагдахууныг тодорхойлох тул тодорхойлолт шаардах шинж чанар
- тухайн сав ухаан, шинжилгээний дэгийн хүрээнд дан утгыг илэрхийлдэг
- найруулгын эгэл нэгж болох чанар зэрэг болно (Равдан, 2014: 25).

Энэхүү дурдсан нь шинэ ухагдахуун нэр томьёоны онцлогийн дагуу зөв оновчтой тодорхойлсноор хэрэглээнд хурдан орж, аливаа хэлний үгийн санг баяжуулна хэмээн ойлгож болох юм. О.Адъяа (2006) “Мэргэжлийн ухагдахууныг нарийн тодорхой, бүрэн дүүрэн илэрхийлэх үг болон нийлэмж үг” гэж тодорхойлсон байна.

Нэр томьёо нь тухайн улс орны ард түмэн мөн харь хэлнээс оролцож бүтнэ. Нэр томьёо нь нэр болон үйлээр холбогдон үүсдэг ба нэр үгээр бүтсэн нэр томьёог улам олшруулбал тухайн хэлний үгийн сан дахь үйл үг цөөрөх бөгөөд үйл үг нь үгийн сангийн чухал хэсэг, өгүүлбэрзүйд үйл үг нь зохион байгуулах төв нь болдог (Лувсанвандан, 2014: 3).

### **Нэр томьёоны бүтэц, тогтолцоо**

Нэр томьёо нь тухайн үндэстний утга зохиолын хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд багтсан үгээс голчлон бүрддэг ба шинээр бий болохдоо ч эх хэлнийхээ үг бүтэх ёсны дагуу бүтдэг.

Нэр томьёог бүтцийн хувьд тэмдгийн, ерөнхий тогтолцооны өөр хоорондоо чанарын гол ялгаатай хэлний ба хэлний бус хэрэглүүрийн төрөл болгон авч үздэг. Хэлний хэрэглүүрт доорх зүйлүүдийг хамруулан ангилдаг (Дашдаваа, 1977: 28).  
Үүнд:

- 1) Нэр томьёо
  - Үүсмэл бус язгуур үг: skill, grade

- Үүсмэл нэр: education, discussion
- 2) Нэр томъёоны нийлэмж
    - Бүрэлдэхүүн үг нь хоёр талын харилцаанд орж болох чөлөөт нийлэмж:
    - Бүрэлдэхүүн үгийг бие биеэс нь тусгаарлахад нэр томъёоны чанараа алдах чөлөөт бус нийлэмж
    - Хэлц үгээр илэрсэн нэр томъёо:
  - 3) Нийлэмж буюу холбоо үгээр бүтсэн нэр томъёог хураангуй нийлэмж үг, дэлгэрэнгүй нийлэмж үгээс бүтсэн нэр томъёо хэмээн ангилж үзэж болох юм. Хураангуй гэдэг нь “үг + үг” гэсэн бүтэцтэй, дэлгэрэнгүй нь 3 болон түүнээс дээш үгээс бүтсэн нэр томъёо юм. Жишээ нь: core curriculum, distance learning
  - 4) Өгүүлбэрээс бүтсэн нэр томъёо. Үүнд: цэрэг арми, биеийн тамир, спортод хэрэглэгддэг командууд багтдаг байна.

## 2. Гадаад нэр томъёог орчуулах, хэрэглэх асуудалд

*Монгол хэлэнд гадаад үгийг шууд хэрэглэх тухай*

Монгол Улсад нэр томъёог тогтоох, жигдлэх, гадаад хэлний үгийг зөв бичиж, орчуулж, хэвшүүлэхэд төр засаг, мэргэжлийн бүх байгууллага ихээхэн анхаарал тавьж ирсэн талаар түүхэн баримт олон байна. БНМАУ-ын СнЗ-ийн Ерөнхий сайд П.Гэндэнгийн 1933 оны 1-р сарын 6-ны өдөр гаргасан 4-р тушаалын заалтад “Өөрийн үндэсний хэл бичгээр дэвсгэр тавьж, Европ дахины шинжлэх ухааны эрдэм ба хувьсгалын суртал боловсролыг өөрсдийн үндсэн бичиг, хэлэнд зөвөөр буулган авах ба суралцах боловсроход түргэн дөхөмтэй болох... нийтэд хэрэглээ бүхий гадаад үгнүүдийг авах хэрэгтэй болохыг тус тус заагаад, үндэсний бичиг үсгийг хөгжүүлэх явдал бол бидний тусгаар тогтносон улсын бататган хөгжүүлэх явдлын нэг чухал нөхцөл мөн.” хэмээн тэмдэглэжээ.

*Дээд боловсролын салбарт гадаад хэлнээс орж ирсэн нэр томъёо*

Судалгааны хэсэгт гадаад хэлнээс монгол хэлэнд орж ирсэн дээд боловсролын салбарын нэр томъёог дараах хоёр толь бичгээс түүвэрлэн авч, ажиглалт хийв. Үүнд:

1. *Боловсролын нэр томъёоны англи – монгол толь*-д гадаад нэр томъёо 76;
2. *Дээд боловсролын нэр томъёоны монгол – англи – орос тайлбар толь*-д гадаад нэр томъёо 28;
3. Хоёр толь бичигт давхардаж орсон гадаад нэр томъёо 18 байна.

Дээрх хоёр толь бичигт нийт 122 гадаад нэр томъёо орсон байна. Тэдгээрээс дээд боловсролын салбарт өргөн хэрэглэгдэж байгаа шинэ нэр томъёог сонгон авч, тэдгээрийн гарал үүсэл, утга, хэрэглээнд дараах байдлаар ажиглалт хийв.

### 1. Course – курс

**Курс** гэдэг үг нь эдийн засгийн салбарт *мөнгөний хани* гэсэн утгаар хэрэглэдэг бол боловсролын салбарт суралцагчдыг ямар нэг нарийн мэргэшлээр бэлтгэх сургалтын газар, их дээд сургуульд суралцах сургалтын жил, дамжааг хэлнэ. Анагаахын салбарт тодорхой хугацаанд хийгдэх курс эмчилгээг хэлнэ. (Монгол хэлний их тайлбар толь)

**Гарал үүсэл:** франц хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Дээд боловсролын салбарт *compulsory course, elective course, course selection* гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг.

## 2. Course Index – хичээлийн индекс

**Гарал үүсэл:** латин хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** All curriculum programs for a bachelor degree, master and doctorate have integrated codes. A code consists of 3 letters. The first letter with dot, in English, indicates the school name. The next 2 letters (also in English) indicates the course, and 3 numbers where the first number marks the level of the course, the next 2 numbers indicate the number of the course.

To illustrate:

- 001-099 Previous level of the course (this does not concern bachelor degree credit hours)
- 100-199 General courses for teacher education
- 200-299 Teacher education courses
- 300-399 Professional and foundation courses
- 400-499 Professional courses

## 3. Credits – Кредит

**Кредит** гэдэг үг нь *зээл, хэн нэгэнд олгох мөнгө, нэр хүнд, итгэл найдвар* зэрэг утгыг илэрхийлдэг. Боловсролын салбарт сурагч, оюутны хичээлд оролцох бүх үйл явцыг тоон үзүүлэлтээр нэгтгэсэн дүгнэлт юм. “Кредит цаг” – хичээлийн цагийг кредит үнэлгээгээр тооцох үйл явц, багц цаг юм” (<https://mongoltoli.mn/>)

**Гарал үүсэл:** франц хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Дээд боловсролын салбарт *earn/collect/receive credit, complete credit hours, credit system, non-credit courses* гэсэн нэр томъёог өргөн хэрэглэж байна.

## 4. Discourse- Дискурс

XX зууны сүүлийн 10 жилд англи, америкийн хэл шинжлэлд дискурс (цогцолбор) гэх нэр томъёо хүч түрэн орж ирсэн. Ерөнхий хэл шинжлэлд энэ нэр томъёоны хэрэглээг оросын хэл шинжээч И.П.Сусов дараах байдлаар тодорхойлсон.

- а) төрөл бүрийн бичвэр
- б) холбоотой, уялдаатай бичвэр
- в) нийгэм- соёлын орчин дахь харилцааны үр дүн

d) авиагаар илэрхийлэгдэж байгаа хэлэхүй, бичгийн хэлбэрт орсон бичвэр (Томтогтох, 2010).

**Гарал үүсэл:** Хэл яриа гэсэн утгатай франц үг.

**Дискурс** гэдэг нь үйл явдлыг хэлхээнд нь авч үзсэн бичвэр; дискурс-товч зарлал, сонины богино мэдээлэл; хүмүүсийн харилцаа. Бичгийн боловсронгуй хэлэнд дискурсийг гол төлөв догол мөрөөр тэмдэглэнэ. Дискурс нь бүлэг санаа, нэгэн юм, хүн үзэгдэл үйлийн тодорхойлолт зэрэг болно. Жишээ нь: Эл байдал дараах хүчин зүйлээр тодорхойлогдоно. Үүнд, 1т, 2т, (Равдан, 2010)

**Хэрэглээ:** Энэ нэр томъёо нь хэл шинжлэлд өргөн хэрэглэгддэг. Жишээ нь: *үндсэн хуулийн дискурс, халдварт өвчний дискурс, эмнэлгийн дискурс, зар сурталчилгааны дискурс, сонин мэдээллийн дискурс, улс төрийн дискурс* зэрэг чиглэлээр хэл шинжлэлийн судалгааны ажлууд хийгдсэн байна.

## 5. Empirical research –Эмпирик судалгаа

**Эмпирик судалгаа** нь аливаа үйл явцыг судлахдаа ажиглалт, туршилт хийж, баримт нотолгоонд суурилсан судалгаа хийхийг хэлнэ. Энэ судалгаа нь дотроо *тоон болон чанарын судалгаа* гэж хоёр хуваагдана. Судлагдахууны хэв шинж, төлөв байдлыг сорилт, туршилт явуулж, баримтаар нотлон тодорхойлж, тэдгээрийг ерөнхийлж, нэгтгэн дүгнэж эмпирик мэдлэгийг бүтээх үйл явцыг туршилтын судалгаа гэнэ.

**Гарал үүсэл:** грек хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** *The researchers conduct empirical research in the field of education.*

## 6. Frascati Manual - Фраскатийн удирдамж

Судалгаа болон хөгжүүлэлттэй холбоотой статистик мэдээллийг цуглуулах, ашиглах талаарх арга зүйг боловсруулсан баримт бичиг юм. (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*)

**Гарал үүсэл:** итали хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Фраскати удирдамжид орсон тодорхойлолтуудыг засгийн газрууд баталж, шинжлэх ухаан, технологийн бодлого, эдийн засгийн хөгжлийн бодлогыг хэлэлцэхэд өргөн ашиглаж байна. Энэ удирдамж нь эхлээд эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан стандарт байсан бол орчим үед судалгаа шинжилгээнд өргөн хэрэглэдэг, дэлхийн дахинд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болсон байна. Жишээ нь: *НҮБ, Европын холбоотой хамтарч ажилладаг олон байгууллагууд тус удирдамжийг өргөн хэрэглэж байна. 2000 оны байдлаар дэлхийн нийт улс орны 75% нь төсвийн талаар мэдээлэл солилцохдоо энэ удирдамжийг ашигласан байна.*

## 7. Impact Factor - Импакт Фактор

**Импакт фактор** гэдэг бол шинжлэх ухааны сэтгүүлийн чансааг илтгэсэн тоон үзүүлэлт юм. Тухайн сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллүүд сэтгүүлдээ хэдэн удаа иш татагдсан тоог импакт фактор гэдэг. 1960 оноос Шинжлэх ухааны мэдээллийн институт/Institute for Scientific Information (ISI) /байгууллага сэтгүүлүүдийн импакт факторыг тооцоолж эхэлсэн байна. Энэ институт нь Томсон Ройтерс компанийн Healthcare & Science business салбарт харьяалагддаг.

Сэтгүүлийн оны импакт фактор бол уг сэтгүүлд өмнөх хоёр жилийн турш хэвлэгдсэн өгүүллүүдийн нийт эшлэлийг нийт өгүүллийн тоонд харьцуулсан харьцаа юм. Жишээлбэл ямар нэг сэтгүүл 2011 онд 2 импакт фактортай байна гэдэг нь 2009 ба 2010 онд уг сэтгүүл хэвлэгдсэн өгүүллүүд дунджаар 2 удаа ишлэгдсэн гэсэн үг юм.

**Гарал үүсэл:** англи хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Эрдэмтэн, судлаачид чанартай судалгааны ажил сонгож унших, өөрийн судалгааны үнэ цэнийг бодитой үнэлүүлэхийн тулд сэтгүүлийн чанарыг зөв үнэлж, сонгож сурах нь нэн чухал юм. Өндөр үнэлгээтэй сэтгүүлд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нь судлаачдын анхаарлыг татдаг. Судлаачид сэтгүүлийн чанарыг үнэлэхдээ импакт фактороос гадна олон үзүүлэлтийг харгалздаг байна.

Дээд боловсролын салбарт эрдэм шинжилгээний өгүүлэл, олон улсын магадлангийн тайлан бичихэд энэ нэр томъёог өргөн хэрэглэж байна. Жишээ нь: *The number of professors of the MNUE who published their research articles in the Thomson-Reuters Impact Factor Journals is increasing year by year.*

## **8. Innovation – Инноваци**

**Инноваци** гэдэг нь шинэ нээлт болон санааг бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ болгон хувиргах үйл явц юм. Үүний үр дүнд баялаг, үнэ цэнэ бүтээгдэж, түүнд хэрэглэгчид төлбөр төлдөг. Технологийн бүтээгдэхүүний инновац нь хэрэглэгчдэд шинэ, сайжруулсан үйлчилгээ хүргэх зорилгоор бүтээгдэхүүний үр дүн, үзүүлэлтийг сайжруулан хэрэгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхийг хэлнэ (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*).

Латин хэлний “innovates” буюу “шинэчлэх, өөрчлөх” гэсэн үгээс үүсэлтэй. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц оюуны бүтээлийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг хэлнэ (<https://www.wikipedia.org/>).

**Гарал үүсэл:** латин хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Дээд боловсролын салбарт *innovation; innovation system; technological process innovation; Office of Research and Innovation* гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг.

## 9. Interactive – Интерактив арга

**Интерактив арга** нь харилцан үйлдэл ба бүлгийн туршлага дээр тулгуурлан суралцагчийг идэвхжүүлэх, эргэх холбоог хангах зарчим дээр үндэслэдэг. Суралцагчийг мэдлэг, туршлагаа хуваалцах замаар сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах арга, технологи бөгөөд суралцах үйл ажиллагааг тодорхойлж, зохион байгуулахад хувь нэмэр оруулдаг. (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*)

**Гарал үүсэл:** англи хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** *Интерактив хичээлийн хэлэлцүүлэг болж байна.*

*Өнөөдөр Туушин зочид буудлын Соёмбо танхимд Теле хичээлийн контент боловсруулах багийнхан интерактив хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Хэлэлцүүлгийн үр дүнд Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсрол болон Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр боловсруулах 104 контентын агуулга, санаагаа гаргаж, контент бүтээх хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг гаргах юм. (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн веб сайт. Үйл явдлын мэдээ. 2020-08-28)*

## 10. Likert scale – Лайкертын шкал

**Лайкертын шкал** нь судалгаанд оролцогчид асуумжид өгөгдсөн нөхцөл байдалтай ямар түвшинд санал нийлж, эсвэл нийлэхгүй байгааг илэрхийлэх хандлагыг хэмжихэд ашигладаг хэмжүүр. (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*)

**Гарал үүсэл:** Англи хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Америкийн нийгмийн сэтгэл зүйч, эрдэмтэн Лайкерт 1932 онд Лайкертын шкал гэж нэрлэгдэх үнэлгээг гаргаж ирсэн ба түүнээс хойш уг үнэлгээний арга зүйг нийгмийн судалгаа, сэтгэл судлалын туршилтад өргөнөөр ашиглах болсон. Уг үнэлгээг тооцохдоо 1 - 5 гэсэн шкал ашигладаг.

- 4.50-5.00 буюу 90%-100% байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшний ойлголт юм.
- 3.50-4.49 буюу 70%-89% байвал хэрэглэгч сэтгэл ханамжтай бөгөөд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэж үздэг.
- 2.50-3.49 буюу 50%-69% хооронд байх тохиолдолд дунд сэтгэл ханамжтай ба цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлдэг.
- 1.50-2.49 буюу 30%-49% хооронд хэрэглэгчид сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд цаашид яаралтай сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлж байгаа юм.
- 1.49-с буюу 29% доош байгаа бол энэ нь хэрэглэгчид огт сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд маш хангалтгүй байгааг илэрхийлнэ.

## 11. Mentoring- Менторинг

Англи хэлний **mentoring** хэмээх үг нь эртний Грекийн домгийн баатар Одиссейн итгэлт анд, зөвлөх Менторын нэрээс үүдэлтэй. Одиссей дайнд мордохдоо итгэлт анд Ментортоо хүүгээ халамжлан хүмүүжүүлж байхыг захиж, даалгасныг Ментор маш сайн биелүүлснээс “мэргэн зөвлөх” (wise adviser) гэсэн утгатай нэрийтгэл нэр болжээ. XVIII зууны дунд үеэс “mentor” хэмээх үгийг “удирдах”, “зөвлөх”, “сурган хүмүүжүүлэх” гэх мэт утгаар хэрэглэсээр иржээ (Мөнхцэцэг, 2020).

**Гарал үүсэл:** Грек хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Гадаад орны дээд боловсролын салбарт *mentor*; *Mentoring Academy*; *Collaborative Mentoring Program* гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг.

МУБИС-ийн багшийн ажлыг үнэлэх журмын сургууль болон нийгэмд үзүүлэх үйлчилгээ 4.4.4 хэсэгт *зөвлөх багш- mentor teacher*, *сургалтын журмын 4.3.18-д зөвлөх багш- mentor*, *дунд сургуулийн зөвлөх багш –secondary school mentor* гэж орчуулсан байна.

## 12. Metacognition - Мета танин мэдэхүй

**Мета танин мэдэхүй** гэдэг нь суралцагч *сурах үйлээ төлөвлөх, хянах, үнэлэх* үйл явцыг хэлнэ. Төлөвлөх явц: Суралцагч, багшийн дэвшүүлсэн сурахуйн зорилгод хүрэхийн тулд дасгал, даалгаврыг ямар аргаар, хэрхэн яаж гүйцэтгэх вэ? гэдгээ төлөвлөнө. Хянах явц: Суралцагчид төлөвлөсөн зүйлээ хэрэгжүүлэх бөгөөд сурахуйн зорилгодоо хүрэхийн тулд ахиц дэвшил гарч байна уу? гэдгээ хянана. Үнэлэх явц: Үр дүнд хэрхэн хүрснээ үнэлж дүгнэнэ. Мета танин мэдэхүй нь бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, сурах үйлээ хянах, сурах үйлээ эргэцүүлэн бодох, үнэлэлт дүгнэлт хийх зэрэг олон чадварыг суралцагчдад олгодог (<https://www.wikipedia.org/>).

Metacognition phases



**Гарал үүсэл:** Грек хэлнээс гаралтай.



**Хэрэглээ:** *As a result of research into metacognition, we understand that the effective use of basic cognitive processes is a fundamental part of learning. These cognitive processes include memory and attention, the activation of prior knowledge, and the use of cognitive strategies to solve a problem or complete a task.*

### 13. Paradigm – Парадигм

Шинжлэх ухааны аливаа салбар, эсвэл төрлийн дотор хийгдэх онол, хууль, дүгнэлт, туршилтуудыг заан чиглүүлж байдаг философи, онолын хүрээ. Парадигмын шилжилт нь үзэл баримтлалын хүрээг өөрчилснөөрөө асуудлыг урьд өмнөхөөс тэс өөрөөр ойлгох, тэдгээрийг шинэ нөхцөл байдалд тохируулан оновчтой шийдвэрлэх, нөөц бололцоог дайчлан ашиглах боломжийг олгодог (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*).

**Гарал үүсэл:** латин хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** *Монголын боловсрол судлалын шинэ парадигм; Шинэ зууны нийгмийн хөгжлийн онцлогтой уялдан Конструктив (constructivism) үзэл баримтлалыг суралцахуйн онолын шинэ парадигм гэж нэрлэх болсон.*

### 14. Rubric - Үнэлгээний рубрик

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хэм хэмжээг оноогоор дүгнэх үнэлгээний хэрэглэгдэхүүн бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт ба түвшин гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Суралцагчид өөрсдийн ажлыг үнэлэх, улмаар засварлах, сайжруулахын тулд рубрик ашиглаж болно. (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*)

Рубрик нь оюутны хийсэн зүйл болон түүнд тохирох чанарын түвшингүүдийг харьцуулан харуулсан үнэлгээний хэрэгсэл юм. Рубрик нь уян хатан бөгөөд суралцахуйн ямар ч үр дүнд тохирдог. Чанарыг шалгах ажил нь хэд хэдэн хүчин зүйлсээс тогтох үед рубрик нь маш сайн тохирдог.

**Гарал үүсэл:** латин хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Үнэлгээний рубрикт гүйцэтгэлийн үнэлгээ, хэмжигдэж буй үзүүлэлтийг харуулсан тодорхойлолт болон жишээ гэх зэрэг нэг болон түүнээс дээш хэмжигдэхүүнтэй байдаг ба хэмжигдэхүүн бүрд тохирсон үнэлгээний шатлал байна. Хэмжигдэхүүнүүд нь ерөнхийдөө шалгуур, үнэлгээний шатлалтай түвшин, тодорхойлолтуудтай тодорхойлогч-с бүрдэнэ. Херман, Асбатчер, болон Винтерс нар үнэлгээний рубрикийн дараах элементүүдийг гаргасан байна.

- Сурагчдын хариултыг дүгнэх үндэс болсон нэг ба түүнээс дээш хэв шинж болон хэмжигдэхүүнүүд байна.
- Хэв шинж ба хэмжигдэхүүн болгоны утгыг тодруулах тодорхойлолт болон жишээнүүд

- Хэмжигдэхүүн бүрийг хэрхэн үнэлэх талаарх шаталсан утга
- Түвшин бүрийн загвар болон жишээг хавсаргасан тодорхой гүйцэтгэлийн түвшний төгс байдлын стандарт 1980 оноос хойш маш олон үнэлгээний рубрикүүд график хэлбэрээр, торон сүлжээ хэлбэрээр гарч ирсэн.

## 15. Standards - Стандарт

**Стандарт** гэдэг нь тодорхой хүрээнд зохимжтой хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг хэлнэ. Standard хэмээх үг нь олон улсын шинжтэй тул орчуулалгүй, үсэгчлэн хэрэглэж хэвшсэн (Мөнхцэцэг, 2020).

Аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зорилгодоо нийцэж буй эсэхийг баталгаажуулах баримт бичиг бөгөөд үүнд тавигдах шаардлага, тодорхойлолт, заавар шинж чанар зэргийг зааж өгдөг. Стандарт гэсэн нэр томъёо нь нэг талаас үр дүнг хэмжих тогтсон шалгуур үзүүлэлт, нөгөө талаас хүрсэн түвшин гэсэн утгатай (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*).

**Гарал үүсэл:** франц хэлнээс гаралтай.

**Хэрэглээ:** Дээд боловсролын салбарт *course standard- хичээлийн стандарт; standard – based training; quality standards; performance standards; standards of excellence* гэсэн нэр томъёог өргөн хэрэглэж байна.

## 16. SWOT analysis - СВOT шинжилгээ

Байгууллага өөрийнхөө дотоод давуу болон сул тал мөн гадаад орчны боломж, аливаа эрсдэлийг тодорхойлох, илрүүлэхэд чиглэсэн стратеги, төлөвлөлтийн техник. (*Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*).

**SWOT шинжилгээ** нь гадаад дотоод орчны нөхцөл байдал түүний давуу ба сул тал, боломж, аюул занал зэргийг бүх талаас нь судлан шинжлэх замаар тодорхойлон үнэлэхэд чиглэгддэг.

**S** – Strengths – Давуу тал

**W** – Weaknesses – Сул тал

**O** – Opportunities – Боломж

**T** – Threats – Аюул занал

**Гарал үүсэл:** Англи хэлний товчилсон үг (Acronym).

**Хэрэглээ:** *Боловсролын хүрээлэнгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, үнэ цэнийг өндөржүүлэх, мөн тус судалгааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулах, чанаржуулах зорилготой стратеги төлөвлөгөө боловсруулахдаа SWOT шинжилгээ хийсэн байна* (Боловсролын хүрээлэн, 2018-2022).

## Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд манай улс гадаад улс оронтой боловсролын хөгжлийн асуудлаар туршлага солилцох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор боловсролын салбарт англи хэлнээс шинэ шинэ ойлголт ухагдахуун олноор бий болж, тэдгээрийг оновчтой орчуулах хэрэгцээ, шаардлага улам бүр тулгарч байна. Гадаад хэлнээс боловсролын салбарт орж ирсэн нэр томъёог зөв оноон нэрлэх, жигдлэхэд хэл шинжээч төдийгүй энэ салбарын судлаачдын үүрэг, оролцоо нэн чухал юм.

Энэ өгүүлэлд *Боловсролын нэр томъёоны англи – монгол толь* (2019), *Дээд боловсролын нэр томъёоны монгол - англи - орос тайлбар толь* (2019)-д орсон шинэ, өргөн хэрэглэгдэж буй гадаад нэр томъёог түүвэрлэн авч, тэдгээрийн гарал, үүсэл, утга, хэрэглээнд ажиглалт хийв. Тэдгээр нэр томъёоны дийлэнх нь латин, франц, англи хэлнээс гаралтай бөгөөд боловсролын үнэлгээ, статистик, судалгаа шинжилгээ зэрэг боловсролын бүх талыг хамарсан өргөн хүрээтэй ойлголт, ухагдахууныг хамарсан үгс байна.

Боловсролын хоёр толь бичигт гадаад нэр томъёо цөөн хувийг эзэлж байгаа нь тус салбарын эрдэмтэн судлаачид судалгаа шинжилгээ хийж, бодлогын баримт бичиг боловсруулахдаа гадаад нэр томъёог монгол хэлэнд оновчтой зөв орчуулах тал дээр хүчин чармайлт гаргаж ирснийг харуулж байна.

Цаашид гадаад хэлнээс орж ирсэн зарим нэр томъёоны орчуулгыг нягтлан сайжруулж хэвшүүлэх нь зүйтэй.

### Translation of Educational Terms

**Uyanga Tavanjin**

*Lecturer, English Department, Mongolian National University of Education  
Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** In recent years, new teaching methods and technologies have been introduced in the field of higher education, and the scope of research has been expanding. Due to this, new terms from foreign languages are used in the field of teaching and research. There is a need for university researchers to study new terms and learn to use them accurately. The first part of this research includes the features, structure, and requirements for terms. In the research part, we studied the origin, meaning and use of some terms that were introduced in the field of higher education from foreign languages.

**Keywords:** Foreign words, word combinations, word origin, meaning, use

Ном зүй

- Жадамба, Б ба бус. (2019). *Боловсролын салбарын англи, монгол толь бичиг*. Улаанбаатар: Соёмбо Принтинг
- БСШУСЯ, Боловсролын хүрээлэн. (2019). *Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь*. Улаанбаатар.
- МУБИС. (2018). *Сургалтын журам*. Улаанбаатар.
- УНТК. (2001). *Нэр томъёо судлал №4*. Улаанбаатар.
- УНТК. (2011). *Нэр томъёо судлал №12-13*. Улаанбаатар.
- МУШУА, Хэл Зохиолын Хүрээлэн. (2014). *Нэр томъёо судлалын өгүүллэгүүд*. Улаанбаатар.
- МУШУА. (2014). *Монгол нэр томъёо судлалын товчоон*. Улаанбаатар.
- Мөнхцэцэг, Н. (2020). *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар.